



Хэнтий аймаг дахь Төрийн
аудитын газар

**БАЯНХУТАГ СУМЫН ЕБС-ИЙН 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Мал амьтдын талаар3

Асуудал 2

Цалингийн зардлын талаар4

Асуудал 3

Шилэн дансны талаар5

Асуудал 4

НББ-ийн бодлогын баримт бичгийн талаар.....6

Менежментийн захидал

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хэнтий аймгийн Баянхутаг сумын ЕБС-ын захирал, нягтлан бодогч нарт талархал илэрхийлье.

АГ-ын ажиглалт

1. Мал амьтдын төлийг орлогод аваагүй, нас дэвшилт хийгээгүй, малын тооллого хийж, тооцоо бодоогүй. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 12.2. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:", 12.2.1. "Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн " 70 дугаар зүйлийн 5 "Ажлын болон өсвөр, үржил, тэжээлд байгаа мал, амьтдыг жилд 1 удаа /12 дугаар сарын 15-ны/ гэсэн заалтыг зөрчиж, " Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

АГ-ын зөвлөмж

1.Малын тооллогыг чанартай үнэн зөв хийж, тооцоог бодон, үлдэгдлийг баталгаажуулах, төлийг орлогод авч, нас дэвшилтийг хийх, түүнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомжийг мөрдөхгүй байх

Төсвийн захирагчийн хариу

АГ-ын ажиглалт

1. Цалингийн зардлаас 364.3 мянган төгрөгийн НДШ-ийн зардлыг төлсөн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-ын "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн Сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын эдийн зсгийн ангилалыг ашиглах заавар"-г зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хнгахгүй байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомжийг мөрдөхгүй байх

АГ-ын зөвлөмж

1. Батлагдсан төсөвт зардлыг зориулалтын дагуу зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх

Төсвийн захирагчийн хариу

АГ-ын ажиглалт

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад: Мэдээлбэл зохих мэдээллээс 14 мэдээг мэдээлээгүй байна. Энэ нь “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна..

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомжийг мөрдөхгүй байх

АГ-ын зөвлөмж

1. Байгууллагын мэдээлвэл зохих мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн хугацаанд үнэн зөв, бүрэн мэдээлж, түүнд тавих дотоод хяналтыг сайжруулах

Төсвийн захирагчийн хариу

АГ-ын ажиглалт

1.НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөөгүй.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “ Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.”, 20.2. “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:”-20.2.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах; гэсэн заалтыг мөрдөөгүй, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

АГ-ын зөвлөмж

1., НББ-ийн хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөх

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомжийг мөрдөхгүй байх

Төсвийн захирагчийн хариу

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ч.ЭРДЭНЭБААТАР

Д.ОЮУНТУЯА

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Б.НАРАНЦЭЦЭГ





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2018-03-05 № 06/89

танай _____ -ны № _____ -т

Г _____ Т _____

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Баянхутаг сумын ЕБС-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхутаг сумын ЕБС-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхутаг сумын ЕБС-ийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Баянхутаг сумын ЕБС нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

195
Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон
Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,
санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭРДЭНЭБААТАР



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**БАЯНХУТАГ СУМЫН ЕБС-ИЙН 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

ТАБ-ын Тэргүүлэх аудитор
Утас: 70562112
Цахим хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 70562147
Цахим хаяг:

Ахлах аудитор: Б.Наранцэцэг
Утас: 70562147
Цахим хаяг:

ТАБ-ын хаяг
Байршил: Хэнтий аймаг Хэрлэн
сум 3-р баг АЗДТГ-ын байр
Цахим хуудас:
Khentii@audit.gov.mn

2018 оны 03 дугаар сар

Аудитын тайлан

- Хавсралт 1: Агуулга
- Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 3: Менежментийн захидал
- Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Нэг.Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхутаг сумын ЕБС-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд /ХЭА-2018/86/СТА-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Баянхутаг сумын ЕБС-ийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Баянхутаг сумын ЕБС-ийн төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Баянхутаг сумын ЕБС-ийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25 -наас 2018 оны 02 дугаар сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын ахлах аудитор Б.Нарацэцэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Баянхутаг сумын ЕБС-ийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2018 оны 02 дүгээр сарын 23-нд ТАБ-д ирүүлсэн байна.

ТАБ аудитыг 2018 оны 02 дүгээр сарын 28 -наас 2018 оны 03 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 13-нд байгууллагын удирдлагад гардуулна.

Хоёр.Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Баянхутаг сумын ЕБС-ийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Боловсролын тухай , Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

Гурав.Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Хэнтий аймгийн Баянхутаг сумын ЕБС нь ““Хүүхэд бүрийг амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадварт бие даан бүтээлчээр суралцах чадамжтай сурагч төлөвшүүлнэ” гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэж заасны дагуу Баянхутаг сумын ЕБС-ийн захирал Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг Баянхутаг сумын Төрийн сангаар дамжуулан аймгийн төрийн сангаас олгож байна

Төсвийн тухай хуулийн 16.5 дугаар зүйлд "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад хяналт тавих, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасан байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хуулиуд бүрэн хэрэгжиж байна.

Баянхутаг сумын ЕБС-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Баянхутаг сумын ЕБС-ийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын горим, нарийвчилсан сорил 13 -г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллага нь ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй байна.

Баянхутаг сумын ЕБС-ийн төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Баянхутаг сумын ЕБС-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Тав. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа

гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байгаа бөгөөд байгууллагын дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн хэмжээнд байна.

Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу аймгийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Баянхутаг сумын ЕБС-ийн төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс 245.4 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд 244.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Долоо. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу цахим хуудсанд 2017 оны байгууллагын үйл ажиллагаа, төсөв хөрөнгийн талаарх мэдээлбэл зохих мэдээллээс 10 мэдээг мэдээлээгүй байна.

Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 чиглэлд 32 эрсдэлтэй асуудлыг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан нийт 13 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал: Тус байгууллага нь мал амьтдын тооллогыг хийж, тооцоо бодоогүй, төлийн орлого авч, нас дэвшилтийг хийгээгүй, цалингийн зардлаас НДШ-ийн зардлыг төлсөн, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй нь санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Ес. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Баянхутаг сумын ЕБС-ийн төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус хэмжээний 4 алдаа илэрсэн байна.

Үүнд: 1. Мал амьтдын талаар

- Мал амьтдын төлийг орлогод аваагүй, нас дэвшилт хийгээгүй, малын тооллого хийж, тооцоо бодоогүй.

Шийдвэрлэсэн: - Малын тооллогыг чанартай үнэн зөв хийж, тооцоог бодон, үлдэгдлийг баталгаажуулах, төлийг орлогод авч, нас дэвшилтийг хийх талаар зөвлөмж өгөв.

2. Цалингийн зардлын талаар

- Цалингийн зардлаас 364.3 мянган төгрөгийн НДШ-ийн зардлыг төлсөн.

Шийдвэрлэсэн: - Батлагдсан төсөвт зардлыг зориулалтын дагуу зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх

3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад: Мэдээлбэл зохих мэдээллээс 10 мэдээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын мэдээлвэл зохих мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн хугацаанд үнэн зөв, бүрэн мэдээлж, түүнд тавих дотоод хяналтыг сайжруулах талаар зөвлөмж өгөв.

4. НББ-ийн бодлогын баримт бичгийн талаар

- НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн хуулийн заалтыг холбогдох заалтыг хэрэгжүүлэн НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөх талаар зөвлөмж өгөв.

Арван нэг. Залруулагдаагүй алдаануудын талаарх асуудал

Материаллаг бус 2.5 сая төгрөгийн 4 алдааг санхүүгийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөл байхгүй тул залруулах шаардлагагүй гэж үзлээ.

Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Баянхутаг сумын ЕБС-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй.

Арван дөрөв.Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Баянхутаг сумын ЕБС-ийн төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2.5 сая төгрөгийн 4 зөрчил илэрч, зөрчлийг дахин давтахгүй байх 4 зөвлөмж өгөв.

Арван тав.Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Баянхутаг сумын ЕБС-ийн 2016 оны санхүүгийн тайланд "Ай Жэй Эй Эйч Аудит" ХХК аудит хийж, 0.6 сая төгрөгийн зөрчил илрүүлэн 4 зөвлөмж өгч, зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна.

Баянхутаг сумын ЕБС нь 1 зөвлөмжөөс бусад зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Арван зургаа.Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхутаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 7 хуудас, менежментийн захидал 5 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

Аудитын тайланг

Хянасан:

Дарга,Тэргүүлэх аудитор

Аудитын менежер

/ Ч.Эрдэнэбаатар/

/ Д.Оюунтуяа/

Бэлтгэсэн:

Ахлах аудитор

/ Б.Наранцэцэг /



Огноо: 2018.03.05